



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 07 өдөр

Дугаар А/461

Улаанбаатар хот

Г Сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэгийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан "Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр"-ийн хавсралтын 3.4.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэгийг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, Сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэгийн бэлтгэл хангах зааварчилгааг хоёрдугаар, Идэвхтэй үзлэгээр илэрсэн сүрьеэгийн оношилгоо, эмчилгээ, хяналт хийх зааварчилгааг гуравдугаар, Идэвхтэй үзлэг зохион байгуулагдах аймаг, дүүргийн хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэгийг 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрүүдэд зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэгийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Т.Энхзаяа/, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д тус тус даалгасугай.

4. Сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэг зохион байгуулахад шаардлагатай санхүүжилтийн хуваарийг нэгдсэн журмаар батлахыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/, батлагдсан санхүүжилтийг Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслөөс санхүүжүүлэхийг төслийн зохицуулагч /Н.Цогзолмаа/ нарт тус тус даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

Сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэг зохион байгуулах удирдамж

1. Үндэслэл:

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Халдварт өвчнөөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сүрьеэгийн илрүүлэлтийг эрчимжүүлэх шаардлагатай байна. Улсын хэмжээнд 2019 оны байдлаар сүрьеэгийн 4089 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь олон улсын байгууллагын тооцсон нийт шинэ өвчлөлийн 31%-ийг илрүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, улсын хэмжээнд 8000 гаруй сүрьеэтэй өвчтөн оношлогдоогүй буюу илрээгүй хэвээр байна.

Цаашид сүрьеэгийн үзлэгийг эрчимжүүлэхэд 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээг эрсдэлт болон зорилтот бүлгийн хүн амыг хамруулан зохион байгуулах, мөн сүрьеэгийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх гол арга хэмжээ болох сүрьеэгийн хавьтлыг илрүүлэх, үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах нь нэн чухал байна.

Түүнчлэн сүрьеэгийн өвчлөл, тархалтыг бууруулах хамгийн үр дүнтэй арга нь илрүүлж эмчлэх, сүрьеэгийн далд халдварыг эмчлэх, хавьтлыг урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулах явдал юм.

2. Зорилго:

Үндэсний хэмжээнд сүрьеэгийн илрүүлэлтийг нэмэгдүүлж, төгс эмчлэх замаар сүрьеэгийн тархалтыг бууруулах.

3. Зорилт:

- 3.1. Сүрьеэгийн эрсдэлт болон зорилтот бүлгийн хүн амын дунд сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэг зохион байгуулах;
- 3.2. Сүрьеэгийн далд халдварыг илрүүлж бүрэн төгс эмчлэх;
- 3.3. Сүрьеэгийн хавьтлуудыг урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулах;

4. Хугацаа:

2020 оны 10 дугаар сараас 2020 оны 12 дугаар сар.

5. Зохион байгуулах байгууллага:

Халдварт өвчин судлалын үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн яам

6. Хамтран ажиллах байгууллага:

- 6.1. Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг;
- 6.2. Өрх, сумын эрүүл мэндийн төв;
- 6.3. Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төсөл;
- 6.4. Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоо, Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо, Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг, Монголын улаан загалмайн нийгэмлэг

7. Бэлтгэл ажил хангах талаар:

7.1. Бэлтгэл хангах:

- 7.1.1 Идэвхтэй үзлэг зохион байгуулах нэгдсэн удирдлагаар хангах / Халдварт өвчин судлалын үндэсний төв зааварчилгаа олгох сургалт явуулах, зааврыг хэвлэн түгээх/;
- 7.1.2 Талбарын баг бүрдүүлэх: аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансэрийн эмч, мэргэжилтнүүд, рентген техникийн эмч, техникч, өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтэн, сайн дурын идэвхтэн /Аймаг, дүүргийн эрүүл мэндийн төв/;
- 7.1.3 Талбарын баг нь Аймаг, нийслэл, дүүрэгт үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах /тушаалын хоёрдугаар хавсралт/; илрүүлэгт хамрагдах иргэдэд мэдээллийг урьдчилан түгээх /Аймаг, дүүргийн эрүүл мэндийн төв/;
- 7.1.4 Сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэгийн бэлтгэл ажилд хяналт тавих / Халдварт өвчин судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн яам, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар /;
- 7.1.5 Коронавируст халдвар (COVID-19)-ын халдвар хамгааллын дэглэмийг мөрдөн ажиллана.

7.2 Сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэг зохион байгуулах:

- 7.2.1 **Асуумжийн аргаар илрүүлэх:** Эмзэг, ядуу иргэдийн дунд сүрьеэгийн хавьтал, шинж тэмдгийг асуух замаар болзошгүй тохиолдлыг илрүүлэн, оношилгоонд хамруулна. Энэхүү үйл ажиллагааг Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг, Монголын улаан загалмайн нийгэмлэгийн сайд дурын ажилтнууд өрх, сумын эрүүл мэндийн төвтэй хамтран гүйцэтгэнэ;
- 7.2.2 **Асуумж ба рентген шинжилгээний аргаар илрүүлэх:** Сүрьеэгийн өрхийн ба ойрын хавьтал, эрсдэлт болон зорилтот бүлгийн хүн ам, хорих ангийн хүмүүжигч нарын дунд асуумж, цээжний рентген шинжилгээнд үндэслэн болзошгүй тохиолдлыг илрүүлж, онош тодруулна.

7.2.3 Дээрх илрүүлэлтийн хүрээнд илэрсэн сүрьеэгийн болзошгүй тохиолдлоос цэрний болон бусад сорьцыг авч, аймаг, дүүргийн болон Сүрьеэгийн лавлах лабораторид нян судлалын /түрхэц, ЖенеЭксперт/ шинжилгээгээр онош баталгаажуулна.

7.2.4 Цээжний рентген зурагт сүрьеэгийн илэрхий өөрчлөлттэй ч нян судлалаар батлагдаагүй тохиолдлуудыг эмнэлзүйн багийн хурлаар хэлэлцүүлэх замаар оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэнэ.

7.3 Сүрьеэгийн оношилгоо, эмчилгээ, хяналт:

7.3.1 Идэвхтэй илрүүлэлтээр илэрсэн сүрьеэгийн нян судлалаар батлагдсан, эмнэлзүйгээр оношлогдсон тохиолдлын цаашдын оношилгоо, эмчилгээ, хяналтыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/306 тоот тушаалын дагуу хийнэ.

7.4 Хяналт, шинжилгээ үнэлгээ хийх

7.5.1 Нийслэлийн хэмжээнд зохион байгуулах сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтэнд Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Глобаль сангаас хамтарсан хяналт үнэлгээг хийнэ.

8. Хүрэх үр дүн:

8.1. Сүрьеэтэй өвчтний хавьтлуудын үзлэг шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ;

8.2. Сүрьеэгийн илрүүлэлтийг улсын хэмжээнд 50-аас дээш хувьд хүргэн нэмэгдүүлнэ.

Сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэгийн бэлтгэл
хангах зааварчилгаа

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/306 тоот тушаалын 9-р хавсралт "Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлт зохион байгуулах заавар"-ын дагуу дараах үндсэн ажлыг зохион байгуулна:

Эрсдэлт бүлгийн хүн ам: Нийт хүн амтай харьцуулахад сүрьеэгийн тархалт эсвэл шинэ өвчлөл харьцангуй өндөр байгаа бүлэг хүн ам юм.

Хавьтал: Сүрьеэтэй өвчтөний халдвартай байх хугацаанд нь түүнтэй хамт (нэг агаартай) байснаар *M.tuberculosis* нянгийн халдварт өртсөн хүнийг хэлнэ.

Сүрьеэгийн далд халдвар: Сүрьеэгийн нянгаар халдварлагдсан ч эмнэлзүйн ямар нэгэн шинж тэмдэг илрээгүй хүн. Энэ тохиолдолд туберкулины арьсны сорил, интерферон гамма (IGRA) тодорхойлох шинжилгээ эерэг байх боловч багажийн болон нян судлалын шинжилгээнд өөрчлөлтгүй байна.

1. Бэлтгэх хангах:

- 1.1. Эрсдэлт болон зорилтот бүлгийн иргэдийн жагсаалтыг сүрьеэгийн илрүүлэх үзлэгийн бүртгэлийн дагуу гаргах /Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/306 дугаар тушаал/, иргэдийн оршин суугаа хаягийн баталгаажилтыг нягтлах, үзлэгт ирсэн эсэхийг тэмдэглэх хэсэгтэй гаргаж, үзлэгт иргэдийг урих талаар мэдээлэл хүргүүлэх.
- 1.2. Сүүлийн 5 жилийн хугацаанд бүртгэгдсэн сүрьеэтэй өвчтөн, тэдний өрхийн болон ойрын хавьтал, иргэдийн судалгааг гаргаж, идэвхтэй илрүүлэлтэнд хамруулах.
- 1.3. Илрүүлэх, үзлэг шинжилгээг зохион байгуулах хуваарийг гаргах, үзлэг хийгдэх байр, талбайг бэлтгэх, илрүүлэлтэнд ашиглагдах дижитал рентген аппарат, ЖенеЭкспертийн оношлуур, сорьц цуглуулах сав, хувийн хамгаалах хэрэгслийн бэлэн байдлыг хангах.

2. Сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэгт хамруулах эрсдэлт болон зорилтот бүлэг:

- 2.1. Эмзэг, ядуу иргэд
- 2.2. Амжиргааны түвшин доогуур иргэд
- 2.3. Өмнө нь сүрьеэгийн эмчилгээнд хамрагдсан иргэд
- 2.4. Сүрьеэгийн хавьтал
- 2.5. ХДХВ-ийн халдвартай иргэд
- 2.6. Чихрийн шижинтэй иргэд
- 2.7. Тураалтай, жин багатай иргэд
- 2.8. Ходоод, гэдэс тайрах мэс ажилбар хийлгэсэн иргэд

- 2.9. Архины хамааралтай иргэд
- 2.10. Дархлаа дарангуйлах эмчилгээ хийлгэж байгаа иргэд
- 2.11. Ахмад настан
- 2.12. Сэтгэцийн эмгэгтэй иргэд
- 2.13. Эмнэлгийн ажилчид

Идэвхтэй үзлэгээр илэрсэн сүрьеэгийн
тохиолдлын оношилгоо

Идэвхтэй үзлэгээр илэрсэн сүрьеэгийн тохиолдлын цаашдын оношилгоо, эмчилгээ, хяналтыг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газрын дэргэд эмнэлзүйн багийг байгуулан, оношийг баталгаажуулна.

1. Онош батлагдаагүй, эргэлзээтэй (цээжний рентген зурагт идэвхтэй/илэрхий сүрьеэгийн өөрчлөлттэй боловч цэрний нян судлалын шинжилгээгээр онош батлагдаагүй) тохиолдлын оношилгоо, эмчилгээ, хяналтын асуудлыг тухайн орон нутгийн эрүүл мэндийн төвийн дэрэгдэх эмнэлзүйн баг хэлэлцэн шийдвэрлэнэ.
2. Эмнэлзүйн баг нь илрүүлэг үзлэгийн асуумж, цээжний рентген зураг, нян судлалын болон бусад шинжилгээний хариуг нягтлан оношийг эцэслэн тогтоох, сүрьеэтэй илэрсэн тохиолдлын эмчилгээнд хяналт тавих үүрэгтэй. Энэ багийн бүрэлдэхүүнд:

- 2.1. Сүрьеэгийн эмч,
- 2.2. Тархвар судлаач эмч,
- 2.3. Дүрс оношилгооны эмч,
- 2.4. Лабораторийн эмч, лаборант,
- 2.5. Мэс заслын эмч,
- 2.6. Хүүхдийн эмч,
- 2.7. Уушгины эмч
- 2.8. Дотоод шүүрлийн эмч байна.

Эрүүл мэндийн сайдын
2020 оны 10 сарын 07 өдрийн 9/ тушаалын
дөрөвдүгээр хавсралт 461

Сүрьеэ илрүүлэх идэвхтэй үзлэг зохион байгуулах
аймаг, дүүргийн хуваарь

№	Аймаг	Хүн амын тоо	Сумын нэр
1	Архангай	1200	Төвшрүүлэх, Өгийнуур, Жаргалант, Эрдэнэбулган
2	Баян-Өлгий	1500	Цэнгэл, Улаанхус, Ногооннуур, Алтай, Өлгий
3	Баянхонгор	1800	Эрдэнэ-Цогт, Бөмбөгөр, Шаргалжуут Галуут, Жаргалант, Баянхонгор
4	Булган	2400	Хялгант, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Булган, Дашинчилэн, Баян-Агт, Сайхан, Бүрэгхангай
5	Говь-Алтай	1500	Есөнбулаг, Шарга, Хөхморьт, Бигэр, Алтай
6	Говьсүмбэр	600	Сүмбэр, Баянтал
7	Дархан -Уул	600	Дархан, Орхон
8	Дорноговь	2400	Замын үүд, Сайншанд, Зүүнбаян, Айраг, Иххэт, Даланжаргалан, Хатанбулаг, Өргөн
9	Дорнод	1500	Баяндун, Баян-Уул, Цагаан-Овоо, Халхгол сум, Хэрлэн сум
10	Дундговь	2100	Адаацаг, Сайнцагаан, Эрдэнэдалай, Хулд, Говь-Угтаал Өлзийт, Гурвансайхан
11	Завхан	2100	Их-Уул, Тэс, Баянтэс, Улиастай, Цэцэн-Уул, Түдэвтэй, Тосонцэнгэл
12	Орхон	600	Баян-Өндөр, Жаргалант
13	Өвөрхангай	2400	Арвайхээр, Бат-Өлзий, Хархорин, Хужирт, Уянга, Тарагт, Өлзийт Нарийнтээл Есөнзүйл
14	Өмнөговь	600	Цогтцэций, Даланзадгад
15	Сүхбаатар	2400	Дарьганга, Наран, Онгон, Халзан, Түмэнцогт
16	Сэлэнгэ	3900	Алтанбулаг, Баянгол, Ерөө, Хүдэр, Цагааннуур, Мандал, Сүхбаатар сум Түнхэл, Хэрх, Тарни, Баянгол,
17	Ховд	1800	Жаргалант, Булган, Манхан, Алтай, Үенч, Мөст
18	Хөвсгөл	1800	Рашаант, Төмөрбулаг, Цагаан-Үүр, Түнэл, Тосонцэнгэл, Тариалан,, Мөрөн
19	Хэнтий	3300	Бор-Өндөр, Хэрлэн, Батширээт, Биндэр, Галшар, Бэрх, Норовлин, Батноров, Баян-Овоо, Өмнөдэлгэр, Мөрөн

20	Төв	2700	Алтанбулаг, Батсүмбэр, Сүмбэр, Бүрэн, Баянцогт, Борнуур, Жаргалант, Цээл, Зуунмод
21	Увс	900	Улаангом, Зүүнговь, Тэс
	Нийт	38100	

Нийслэлийн 9 дүүргийн сонгогдсон 100 хороо				
№	Дүүрэг	Хүн амын тоо	Хороодын тоо	Хорооны дугаар
1	Баянгол	4500	15	2, 3, 4, 5, 6, 7, 8, 10, 11, 12, 23,
2	Баянзүрх	6600	22	2, 4, 5, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 15, 16, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27
3	Сонгинохайрхан	6600	22	1, 2, 3, 4, 6, 7, 8, 9, 10, 14, 15, 19, 21, 22, 23
4	Чингэлтэй	3300	11	7, 9, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19
5	Сүхбаатар	3300	11	1, 2, 3, 9, 10, 11, 12, 15, 19, 14, 16, 18, 20
6	Хан-Уул	3600	12	1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 10, 12, 14, 15
7	Налайх	900	3	1, 2, 4, 5, 7
8	Багануур	900	3	1, 2, 4, 5
9	Багахангай	300	1	1, 2
	Нийт	30000	9 дүүргийн 100 хороо	

Сүрьеэгийн өвчний тархалт (Prevalence): “Монгол Улсын хүн амын дундах сүрьеэгийн тархалтыг тогтоох судалгаа 2014-2015” -аар анх удаа өвчний тархалтыг тодорхойлсон. Үүний үр дүнгээс харахад сүрьеэ өвчний тархалт өмнөх тооцооллоос даруй 3 дахин өндөр байв. Бүх насны хүн амын дундах уушгины сүрьеэ өвчний тархалт 100,000 хүн амд 441 (95% CI: 366 – 515), бүх хэлбэрийн сүрьеэгийн тархалт 100,000 хүн амд 757 (95% CI: 620-894) байна. Сүрьеэгийн тархалт 25-34 насны залуучуудын дунд хамгийн өндөр, нас ахих тусам нэмэгдэх хандлагатай бөгөөд эрэгтэйчүүдийн дунд төвлөрч байгаа нь ажиглагдсан. Түүнчлэн, сүрьеэгийн тархалт хот, аймгийн төв, хөдөө сумдад ижил түвшинд байсан.

Сүрьеэгийн шинэ өвчлөл (Incidence): Сүрьеэ өвчний тархалтын дээрх шинэ тооцоололд үндэслэн 100,000 хүн амд тутамд 428 (95% CI: 220-703) шинэ өвчлөл бий болдог гэж тооцвол сүрьеэгийн шинэ өвчлөлөөр дэлхийд 10 дугаарт бичигдэж байна. Өөрөөр хэлбэл, 2018 онд сүрьеэгийн 13,600 тохиолдол сүрьеэгээр өвчилсөн бол тэдний гуравны нэг (Илрүүлэлтийн түвшин 29%, 3880 тохиолдол) нь бүртгэгдэж, эмчилгээнд хамрагдсан бол дийлэнх 71% нь илрээгүй байна.

Таамаглал:

№	Тооцоолол	Дүүргийн нэрс	Хамруулах хүн ам	Сорьц цуглуулах тоо 20%	Илрүүлэх тохиолдол
1	100/2	116 сум 8 тосгон, 100 хороо	68100	13620	1362

Тайлбар:

Нийт эрсдэлт бүлгийн 68100 хүн сүрьеэ илрүүлэх үзлэгт хамрагдана. Үүнээс сүрьеэгийн сэжигтэй 13620 (20%) тохиолдолд сорьц цуглуулж 1362 сүрьеэгийн тохиолдол илрүүлнэ гэж тооцоолж байна.